



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/419.

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх хэсэг, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Жаргалант сумын Бугат багийн Шинэ суурьшлын бүс, хаус хотхон 30 айлын амины орон сууцны зориулалттай “Бат дайчин” ХХК /4073886/-ийн эзэмшлийн 6000 метр квадрат газраас 73 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Чимэгбатын Ганбаяр /ПЙ93082013/-д шилжүүлж, амины орон сууцны зориулалтаар, хаягийг Бат монгол 1 дүгээр гудамжны 104 тоот болгон 15 жилийн хугацаагаар,

2. Жаргалант сумын Бугат багийн Шинэ суурьшлын бүс, хаус хотхон 30 айлын амины орон сууцны зориулалттай “Бат дайчин” ХХК /4073886/-ийн эзэмшлийн 6000 метр квадрат газраас 90 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Жамбалын Сарангэрэл /ИД88122424/-д шилжүүлж, амины орон сууцны зориулалтаар, хаягийг Бат монгол 2 дугаар гудамжны 208 тоот болгон 15 жилийн хугацаагаар,

3. Жаргалант сумын Цамбагарав баг хүнсний комбинатын дэлгүүртэй залгаа байрлах худалдаа үйлчилгээний зориулалттай Дүгэрхүүгийн Энхсайхан /ПЮ67100418/-ийн эзэмшлийн 300 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Дүгэрхүүгийн Энхтуяа /УС64083126/-д газрын хэмжээг кадастрын мэдээллийн сангийн зургийн дагуу 288 метр квадрат, худалдаа, үйлчилгээний зориулалтаар хаягийг Заны 1 дүгээр гудамжны 118 тоот болгон 15 жилийн хугацаагаар,

4. Жаргалант сумын Цамбагарав баг Заны 3 дугаар гудамжны 309 а тоотод байрлах, худалдаа үйлчилгээний зориулалттай Мөнхбатын Нямсүрэн /ПЖ91011905/-ийн эзэмшлийн 68 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Лутаагийн Отгонбаяр /ПЖ92021207/-д худалдаа, үйлчилгээний зориулалтаар 11 жилийн хугацаагаар,

5. Жаргалант сумын Жаргалан баг Залуус 4 дүгээр гудамжны 413 тоотод байрлах, худалдаа үйлчилгээний зориулалттай Дашцэрэнгийн Төмөрсүх /ПЮ67022578/-ийн эзэмшлийн 209 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Бандийн Сундуйжав /ПК73071519/-д худалдаа, үйлчилгээний зориулалтаар 7 жилийн хугацаагаар,

6. Жаргалант сумын Жаргалан баг Орчлон 1 дүгээр гудамжны 103 тоотод байрлах, худалдаа үйлчилгээний зориулалттай Бүүвээгийн Булган /ПЮ77091364/-ийн эзэмшлийн 520 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Бүүвээгийн Ариунаа /ПЮ74091661/-д худалдаа, үйлчилгээний зориулалтаар 5 жилийн хугацаагаар,

7. Жаргалант сумын Магсаржав баг 1 дүгээр гудамжны 20 тоотод байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай Уртнасангийн Төр-Очир /П365082718/-ийн эзэмшлийн 657 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Батчулууны Батзаяа /ПЮ89091775/-д газрын хэмжээг кадастрын мэдээллийн сангийн зургийн дагуу 745 метр квадрат, орон сууцны зориулалтаар хаягийг Амарсанаагийн 7 дүгээр гудамжны 724 тоот болгон 5 жилийн хугацаагаар тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

8. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлэн авч, газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлэхийг дээрх иргэдэд үүрэг болгосугай.

9. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ